

**ЖАРГАЛАНТ СУМЫН ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН
СЭРГИЙЛЭХ АЖЛЫГ ЗОХИЦУУЛАХ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН
2014 ОНД ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН**

2014 оны 12 дугаар сарын 01

Эмээл толгой

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн хурлыг улиралд 1 удаа хуралдаж, хурлаар гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлөөс 2014 онд хийх ажлын төлөвлөгөө, морин эргүүл ажиллуулах, бусад асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэсэн.

Сумын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн 2014 оны ажлын төлөвлөгөөнд 4 бүлэг 32 заалт төлөвлөснөөс 27 заалт бүрэн хэрэгжиж, 3 заалт хэрэгжих шатандаа буюу хугацаа болоогүй, 2 заалт огт хэрэгжээгүй байна.

Нэг. Архидан согтуурахтай тэмцэх ажлын хүрээнд:

1.1 Сумын Засаг даргын Тамгын газар, Цагдаагийн хэсэгтэй хамтран Архигүй Монгол” Ерөнхийлөгчийн уриалгыг дэмжиж, ирээдүйг бүтээгч залуусын ухамсарт эергээр нөлөөлөх “Аюулгүй амгалан Жаргалантын иргэд” нээлттэй хэлэлцүүлгийг 2014 оны 9 дүгээр сарын 18- ны өдөр Иргэний танхимд зохион байгуулсан. Хэлэлцүүлгийн зорилго нь залгамж хойч үеэр архи тамхинаас татгалзаж 3-аас дээш жил болж буй иргэдийн сэтгэгдлийг сонсгож, залуусын ухамсарт архи, тамхины хэрэглээ эрүүл мэнд болон эдийн засагт ямар их гарз хохирол амсуулдаг болохыг нээлттэй ярилцахад оршиж байлаа. Мөн архи тамхинаас татгалзаж 3-аас дээш жил болж буй иргэдээ урилгаар оролцуулан хүндэтгэл үзүүлсэн. Иргэдийн маань ухамсар дээшилж, сумын хэмжээнд 13 иргэн архи тамхинаас бүр мөсөн гарсан байна.

1.2 2014 оны 09 дүгээр сарын 01-нд Байдраг ахлах сургуулийн захиралтай хамтран 8-12 дугаар ангийн сурагчдад Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль, Тамхины хяналтын тухай хууль болон гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль, замын хөдөлгөөний дүрэм зэргээр сургуулийн захиргаатай хамтран яриа таниулга хийж гэмт хэрэг зөрчилгүй сургууль болох уриалга гаргасан.

1.3 Сургуулийн эмч Ц.Намжилмаа, нийгмийн ажилтан Г.Нарангэрэл, бичиг хэргийн ажилтан С.Алтанчойж нар Өсвөр үеийнхэнд “Архи, тамхи, мансууруулах

бодисны хор уршиг түүнээс урьдчилан сэргийлье” сэдэвт сургалтыг 2 удаа зохион байгуулж 8-11 дүгээр ангийн 98 сурагч хамрагдсан.

1.4 Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүд бусад ой, түүхэн үйл явдал, салбарын болон зарим ажил мэргэжлийн ажилтан, ажилчдын өдөр, олон улсын байгууллагаас дэлхий нийтээр тэмдэглэхээр тогтсон өдрүүдийг архигүй тэмдэглэх уриалга гаргасан.

1.4 Архины тухай, Тамхины хяналтын тухай хуулиудын хэрэгжилтэнд байнга хяналт тавин ажиллаж байна.

Хоёр. Хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр:

2.1 Сумын ГХУСАЗСЗ-ийн гишүүд малын хулгай ихээр гардаг Нам толгойн 1-р багаар тойрч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага өөрийн өмчлөл, эзэмшилд байгаа мал сүргээ хамгаалах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлийн сургалт, сурталчилгаа зохион байгуулсан.

2.2 2014 оны 05 дугаар хөдөөгийн 3-н багт нийт 6 малчдын малчдын бүлэг байгуулагдсан. Эдгээр малчдын бүлгийн гишүүд нь чиглэл чиглэлд хуваарилагдан малчдад малын хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, малыг им тамгажуулах, малаа эзэнгүй явуулахгүй байх талаар ухуулга сурталчилгааг байнга хийж байгаагийн зэрэгцээ мал мах бэлтгэж байгаа иргэдэд хараа хяналт тавин ажиллаж байна. Мөн сумын хэмжээнд мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, илрүүлэх ажлын үр бүтээлийг дээшлүүлэх, энэ төрлийн гэмт хэргийн гаралтыг бууруулах чиглэлээр баг бүрт морин эргүүл ажиллуулж байна. Морин эргүүл ажиллуулснаар малын хулгайн гэмт хэргийн гаралт буурч, илрэлт сайжирч байна.

2.3 Сумын ГХУСАЗ салбар зөвлөл, Цагдаагийн байгууллагатай хамтарч . “Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэе”, хэлэлцүүлэг зохион байгуулж, хэлэлцүүлэгт оролцогчдоос иргэд, малчдад хандан уриалга гаргасан. Хэлэлцүүлэгт ИТХ-ын дарга, сумын Засаг дарга, багийн Засаг дарга нар, Хэсгийн төлөөлөгч, малчдын төлөөлөл 30 гаруй хүн оролцсон.

2.4 Баянхонгор аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, Цагдаагийн газартай хамтарч "Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэхэд иргэд төрийн байгууллагын хамтын ажиллагаа" сэдэвт зөвлөгөөнийг 2014 оны 10 дугаар сарын 03-ны өдөр зохион байгуулсан. Зөвлөгөөнд аймгийн ИТХ-ын дарга Д.Ширмэн, ЗДТГ-ын Хууль зүйн хэлтсийн дарга С.Баярмаа, Цагдаагийн газрын дарга Б.Оюутболд, ШШГА-ны дарга

Ч.Баяр, аймгийн ГХУСАЗЗ-ийн гишүүд болон хангайн бүсийн сумдын удирдлагууд, иргэд, малчдын төлөөлөл оролцсон.

Гурав. Зам тээврийн осол зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр:

3.1 Зам тээврийн ослоос урьдчилан сэргийлж замын тэмдэг тэмдэглээ хийсэн. Үүнд хурд сааруулагч 2 ш, гудамж талбайн өнцөг буланд тэмдэглэгээ хийж, зарим гудамжны өнцөгт дугуйгаар хаалт хийж, будсан. Сургуулийн хажуугийн замыг хааж, хүүхдүүдийг хөдөлгөөний аюулгүй байдалд өртөхөөс урьдчилан сэргийлэх ажлыг хийж гүйцэтгэлээ.

3.2 Жаргалант сумын хэмжээнд 2014 оны эхний 10 сарын байдлаар тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал хангаагүй явснаас 2 хүн амь насаа алдсан гэмт хэрэг гарсан. Иймд сумын төвийн тээврийн хэрэгслийн 19 жолоочид хөдөлгөөний аюулгүй байдлын талаар сургалт зохион байгуулсан. Мөн тус сумын хүн тээврийн жолооч нарыг тээврийн биржтэй гэрээ хийлгэж, зорчигч нарын ая тухтай аюулгүй зорчих эрхийг хангаж өгсөн.

Дөрөв. Байгаль орчныг хамгаалах чиглэлээр:

4.1 АНУ-ын Азийн сангийн "Байгаль орчныг хамгаалахад талуудын оролцоог нэмэгдүүлэх нь-II" төсөлд шалгарч, уг төслийн хүрээнд тус сумын Мандалын Бөөрөгийн Зүүн салааны 6 га газарт өртөг багатай аргачлалаар эдвэрсэн газарт нөхөн сэргээлтийн ажлыг "Байдрагийн хөгжил" ТББ хийж гүйцэтгэсэн. Нийт 6 га газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийж, ойролцоо ургадаг модлог ургамалыг тарьж ургуулан, олон настын үр цацсан. Энэ нь байгаль орчныг хамгаалахад олон талын оролцоотойгоор хийгдсэн шинэлэг ажил юм.

4.2 Байдраг ахлах сургуультай хамтран иргэд, хүүхэд залуучуудыг эх орон, байгаль, газар шороогоо хайрладаг, эх орноороо бахархдаг хүн бүхэн эх орны хөгжлийн төлөө гэсэн чин сэтгэлтэй болгон төлөвшүүлэх зорилгоор 1 сая гаруй төгрөгийн зурагт санамж бэлтгэн хэвлүүлж, сургуулийн ойр орчимд байршуулсан.

4.3 2014 оны 09 дүгээр сарын 4-5 нд сумын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөлийн гишүүд, Цагдаагийн хэсэг, Байгаль хамгаалагч Б.Санжаасүрэн, Хөндлөн булаг 3-р багийн Засаг дарга А.Лхагвадорж нар 3-р багийн малчин Сүхбаатар, Батаа, Дамдин, Эрдэнэчулуун, Мөнхжаргал нарын нийт 10 гаруй хүний бүрэлдэхүүнтэй Байдраг голын эх Гурван голын сав газраар 2 хоно хориотой ан агнуурын эргүүл шалгалт хийж, шалгалтаар 1200 га газар хууль бусаар тарваганы нүхэнд урхи зүүсэн байсан 70 урхи хураан авсан. Гурван тарвага урхинд орсон байхад нь авч устгал хийсэн.

Тав. Бусад ажлын талаар:

5.1 Цагдаагийн албан хаагчдыг хамгаалах хэрэгслээр /гав 1 ширхэг, цахилгаан бороохой 2 ширхэг/ хангасан.

5.2 Хүнсний аюулгүй байдлыг хангах үндсэн дээр сумын төвийн 13 хүнсний дэлгүүр, гал тогоо бүхий газруудад хэрэглэгчдийг хамгаалах нийгэмлэг, олон нийтийн байцаагч, хөдөө аж ахуйн улсын байцаагч нартай хамтарч 2 удаа шалгалт хийж, зөрчлийг арилгах талаар үүрэг даалгавар өгч, биелэлтийг дахин шалгасан болно.

5.3 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр нийтийг хамарсан болон тэмдэглэлт баярын өдрүүдэд сумын Засаг даргын 2014 оны 06 дугаар захирамжаар байгууллагуудаас хариуцлагатай эргүүл, жижүүр ажиллуулсан. Эргүүлд 6 байгууллагын 24 албан хаагч хариуцлагатай эргүүл хийж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгах арга хэмжээ авсан.

5.4 Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиар байгууллага иргэдийн дунд асуулт хариултын тэмцээн зохион байгуулж, нийт 400 гаруй иргэнд гарын авлага тараасан

5.5 Жаргалант сумын 3-р багийн нутаг “Мандалын Бөөрөг” гэх газар гар аргаар алт олборлож байгаа иргэдтэй уулзаж Архи, тамхины тухай хууль Хөдөлмөр хамгаалалын аюулгүй байдлын тухай хууль Хөдөлгөөний аюулгүй байдал хуулиар 2 удаа сургалт зохион явуулсан.

5.6 Сумын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөлийн дарга болон гишүүд албан байгууллагуудын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хийж буй ажилтай танилцаж, цаашид хийх ажлын талаар чиглэл өгсөн.

5.7 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хийж буй ажил болон гарч буй гэмт хэргийн талаар мэдээллийн самбар болон гарын авлага хийж иргэдэд мэдээлж байна.

5.8 Жаргалант суманд бүртгэгдсэн гэмт хэргийн гаралтыг сүүлийн 3 жилээр харьцуулбал 2011 онд 9, 2012 онд 7 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх онтой харьцуулахад 2 хэргээр буюу 22,2 хувиар буурсан, 2013 онд 6 гэмт хэрэг бүртгэгдсэн нь урьд онтой харьцуулахад 1 хэргээр буюу 14,2 хувиар буурсан байна. 2013 онд гарсан гэмт хэргийг өнгөөр нь ялгавал өмчийн хулгай 4, үүнээс малын хулгай 3, иргэдийн өмчийн хулгай 1, бусдын бие махбодид гэмтэл учруулах хэрэг 1,

бусад гэмт хэрэг 1 бүртгэгдсэн байна. Тус суманд сүүлийн 3 жилд гэмт хэрэг буурсан үзүүлэлттэй байна.

	ТАЙЛАН БИЧСЭН	
ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮН		Д.УРАНЧИМЭГ
	ХЯНАСАН	
ДАРГА	Д.ГАНТӨМӨР	